ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/023/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитор: Б.Оюунхэрлэн<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.23 № 69

танай ____________-ны № ______________-т

ДОРНОД АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Д.МӨНХБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засаг дарга 85.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2125020191

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,367,771,311.75** | **2,338,135,965.22** |
| **33** | **АВЛАГА** | 3,494,205.80 | 3,069,980.27 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 125,798.07 |
| **335** | **Бусад авлага** | 3,494,205.80 | 2,944,182.20 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 3,494,205.80 | 2,944,182.20 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2,364,277,105.95 | 2,335,065,984.95 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,189,289,229.33 | 2,153,481,668.33 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,189,224,229.33 | 2,153,416,668.33 |
| 35130 | Эм боох материал | 65,000.00 | 65,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 51,478,876.62 | 55,555,316.62 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,732,930.00 | 3,285,370.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 47,037,446.62 | 51,561,446.62 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 708,500.00 | 708,500.00 |
| 35600 | Мал амьтад | 123,509,000.00 | 126,029,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,452,649,278.53** | **3,337,795,202.19** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,452,649,278.53 | 3,337,795,202.19 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,910,729,278.37 | 2,796,095,202.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,719,940,669.00 | 2,719,940,669.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (123,191,777.08) | (173,971,524.64) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 401,226,972.73 | 316,226,972.73 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (272,144,806.33) | (226,493,185.53) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 235,035,738.66 | 241,896,132.32 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (116,628,008.19) | (133,634,519.85) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 110,683,050.17 | 110,308,056.17 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (44,192,560.59) | (58,177,398.01) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 541,920,000.16 | 541,700,000.00 |
| 39301 | Програм хангамж | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,779,999.84) | (7,000,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 541,700,000.00 | 541,700,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,820,420,590.28** | **5,675,931,167.41** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **2,259,389.88** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 2,259,389.88 |
| **413** | **Өглөг** | - | 2,259,389.88 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 1,456,461.88 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 84,278.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 718,650.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 718,650.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,820,420,590.28** | **5,673,671,777.53** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,820,420,590.28 | 5,673,671,777.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,231,692,767.15 | 1,231,692,767.15 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,231,692,767.15 | 1,231,692,767.15 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,580,701,977.82 | 4,433,953,165.07 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,514,416,042.90 | 4,580,701,977.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,066,285,934.92 | (146,748,812.75) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 8,025,845.31 | 8,025,845.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,820,420,590.28** | **5,675,931,167.41** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,594,208,239.77** | **1,164,228,784.89** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,368,872,903.77** | **57,238,468.89** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,368,872,903.77 | 57,238,468.89 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 122,679,744.95 | 45,263,468.89 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,246,193,158.82 | 11,975,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,225,335,336.00** | **1,106,990,316.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,108,556,900.00 | 868,483,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,108,556,900.00 | 868,483,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 116,778,436.00 | 238,507,116.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 77,984,081.00 | 193,943,150.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,915,438.00 | 828,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,878,917.00 | 43,735,766.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,389,113,629.65** | **1,280,558,748.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,389,113,629.65** | **1,280,558,748.84** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,185,639,276.32 | 1,252,419,913.89 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 691,037,091.00 | 761,722,020.88 |
| 210101 | Үндсэн цалин | 370,438,082.35 | 377,986,608.45 |
| 210102 | Нэмэгдэл | 251,291,407.00 | 298,264,955.88 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,504,182.65 | 33,836,800.00 |
| 210104 | Урамшуулал | 42,803,419.00 | 51,633,656.55 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 86,339,988.39 | 91,757,676.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,497,329.45 | 64,489,776.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,850,258.18 | 6,816,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,597,973.54 | 3,408,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,399,493.38 | 3,408,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,994,933.84 | 13,633,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,925,000.00 | 10,872,743.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,654,200.00 | 3,918,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,934,848.00 | 5,310,565.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 335,952.00 | 1,644,078.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 64,728,276.00 | 20,396,249.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,069,900.00 | 2,515,710.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,907,736.00 | 16,066,589.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 717,900.00 | 390,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,807,740.00 | 1,078,450.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 23,225,000.00 | 345,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,502,700.00 | 4,750,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,502,700.00 | 4,750,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,308,600.00 | 21,454,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,308,600.00 | 21,454,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 144,871,945.28 | 170,232,577.92 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 129,625,419.28 | 164,684,252.92 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,276.00 | 626,008.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 24,500.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,860,000.00 | 660,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4,214,750.00 | 4,218,317.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 158,925,675.65 | 171,233,545.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,792,220.00 | 10,746,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 370,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 155,133,455.65 | 160,117,545.23 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 203,474,353.33 | 28,138,834.95 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 83,059,248.00 | 20,878,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,220,000.00 | 3,849,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 73,144,248.00 | 16,029,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,695,000.00 | 1,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 120,415,105.33 | 7,260,834.95 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 85,214,347.61 | 3,755,859.07 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 35,200,757.72 | 3,504,975.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,205,094,610.12** | **(116,329,963.95)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 138,808,675.20 | 30,418,848.80 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 138,808,675.20 | 30,418,848.80 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (138,808,675.20) | (30,418,848.80) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,066,285,934.92** | **(146,748,812.75)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,256,543,294.00** | **1,115,145,051.80** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,256,543,294.00** | **1,115,145,051.80** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,108,556,900.00 | 868,483,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,108,556,900.00 | 868,483,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 147,986,394.00 | 246,661,851.80 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 77,984,081.00 | 193,943,150.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,915,438.00 | 828,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 59,086,875.00 | 51,890,501.80 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,256,543,294.00** | **1,115,145,051.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,256,543,294.00** | **1,115,145,051.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,052,037,000.67** | **1,087,724,866.85** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 693,002,881.39 | 760,265,559.00 |
| 210101 | Үндсэн цалин | 372,403,872.74 | 377,986,608.45 |
| 210102 | Нэмэгдэл | 251,291,407.00 | 296,808,494.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,504,182.65 | 33,836,800.00 |
| 210104 | Урамшуулал | 42,803,419.00 | 51,633,656.55 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 84,374,198.00 | 91,883,475.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,721,198.00 | 64,615,575.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,663,300.00 | 6,816,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,331,600.00 | 3,408,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,331,600.00 | 3,408,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,326,500.00 | 13,633,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,925,000.00 | 10,846,965.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,654,200.00 | 3,918,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,934,848.00 | 5,310,565.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 335,952.00 | 1,618,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,750,040.00 | 14,701,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,323,700.00 | 1,527,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,890,500.00 | 11,788,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 717,900.00 | 390,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 817,940.00 | 996,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,090,800.00 | 2,996,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,090,800.00 | 2,996,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,308,600.00 | 21,454,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,308,600.00 | 21,454,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 201,402,881.28 | 185,206,566.92 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 186,156,355.28 | 179,658,241.92 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,276.00 | 626,008.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 24,500.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,860,000.00 | 660,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4,214,750.00 | 4,218,317.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,182,600.00 | 370,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,182,600.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 370,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **204,506,293.33** | **27,420,184.95** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 84,091,188.00 | 20,159,350.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,220,000.00 | 3,849,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 73,144,248.00 | 15,310,350.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,726,940.00 | 1,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 120,415,105.33 | 7,260,834.95 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 85,214,347.61 | 3,755,859.07 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 35,200,757.72 | 3,504,975.88 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,231,692,767.15 | 8,025,845.31 | 2,514,416,042.90 | 3,754,134,655.36 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,231,692,767.15** | **8,025,845.31** | **2,514,416,042.90** | 3,754,134,655.36 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 2,066,285,934.92 | 2,066,285,934.92 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,231,692,767.15** | **8,025,845.31** | **4,580,701,977.82** | 5,820,420,590.28 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,231,692,767.15** | **8,025,845.31** | **4,580,701,977.82** | 5,820,420,590.28 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,231,692,767.15** | **8,025,845.31** | **4,580,701,977.82** | 5,820,420,590.28 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -146,748,812.75 | -146,748,812.75 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,231,692,767.15** | **8,025,845.31** | **4,433,953,165.07** | 5,673,671,777.53 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **12200** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 961,819,200.00 | 864,727,340.93 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 961,819,200.00 | 864,727,340.93 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | 961,819,200.00 | 864,727,340.93 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 964,195,600.00 | 864,727,340.93 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 939,931,400.00 | 844,567,990.93 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 703,471,600.00 | 703,471,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 409,316,300.00 | 377,986,608.45 |
| 210102 | Нэмэгдэл | 209,791,100.00 | 240,014,535.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,443,300.00 | 33,836,800.00 |
| 210104 | Урамшуулал | 50,920,900.00 | 51,633,656.55 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 85,178,800.00 | 85,178,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,910,900.00 | 57,910,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,816,800.00 | 6,816,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,408,600.00 | 3,408,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,408,600.00 | 3,408,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,633,900.00 | 13,633,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,016,900.00 | 10,846,965.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,347,200.00 | 3,918,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,051,400.00 | 5,310,565.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,618,300.00 | 1,618,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,783,700.00 | 14,701,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,567,800.00 | 1,527,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,788,200.00 | 11,788,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 583,900.00 | 390,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,843,800.00 | 996,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,165,000.00 | 2,996,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,075,000.00 | 2,996,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 90,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 26,306,800.00 | 21,454,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 26,306,800.00 | 21,454,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 92,140,000.00 | 5,548,325.00 |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 75,932,700.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 72,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо | 761,400.00 | 626,008.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 221,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,200,000.00 | 660,000.00 |
| 210807 | Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж | 7,952,900.00 | 4,218,317.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,868,600.00 | 370,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,498,600.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 370,000.00 | 370,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 24,264,200.00 | 20,159,350.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,264,200.00 | 20,159,350.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,849,000.00 | 3,849,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 18,849,600.00 | 15,310,350.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,565,600.00 | 1,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | 964,195,600.00 | 864,727,340.93 |

## Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар 93.3 сая төгрөгийн 1 алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт батлагдсан төсвийг бүрэн тусгалгүй, олгоогүй санхүүжилтийг хасаж тайлагнасан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2,365.1 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 35.3 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч, 2,328.2 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож ажиллалаа.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт* Төрийн захиргааны албан тушаалд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа албан хаагчид 5 жил тутамд 1 удаа олгох мөнгөн урамшууллыг олгохдоо сүүлийн 5 жилийн (2020-2025) нийгмийн даатгалын лавлагааг хавсаргаагүй, өмнөх онуудын (2018-2022) лавлагааг хавсаргаж олгосон. Энэ нь Засгийн газрын 83-р тогтоолоор баталсан Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3.5.Төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт бичиг нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, нийгмийн даатгалын дэвтэр, сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт ажилд томилсон, өөр албан тушаалд шилжүүлэн, сэлгэн ажиллуулсан тушаал болон холбогдох бусад баримт бичиг байна. гэж заасны дагуу үндсэн баримт бичгийн шаардлага хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж* Засгийн газрын 83-р тогтоолоор баталсан Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамд заасан үндсэн баримт бичгийг зохистой бүрдүүлэх зөвлөмж өгөх.

2. Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт, тайлагналтай холбоотой

*Илрүүлэлт* Оффисын барилгын ашиглалтын гэрээний дагуу 2 байгууллагын ашиглалтын төлбөр нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин ордог байна. Тухайн гүйлгээг байгууллага хоорондын тооцоо үүсгэлгүй, өөрийн орлого зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Энэ нь тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Мөн төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 2.1.Орлого гэж байгууллагын хувь нийлүүлэгчдийн хувь оролцооноос бусад байдлаар цэвэр хөрөнгө буюу өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхын нийт орлогын гүйлгээ юм. 3.1.Зардал гэж өмчлөлийн хуваарилалтаас үүссэн багасалтаас бусад байдлаар тухайн байгууллагын цэвэр санхүүгийн байдалд гарсан бууралт юм гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж* Цаашид дамжин орж байгаа өөр байгууллагын ашиглалтын төлбөрийн дүнгээр тухайн байгууллагаас авлага үүсгэн ((Дт: Байгууллагаас авах авлага Дт: Байр ашиглалтын зардал /өөрийн байгууллагад хамаарах зардлын дүнгээр/ Кт:Ашиглалтын зардлын өглөг /нийт төлөх дүнгээр/) гэж бүртгэх

**3.2 Албан шаардлага**

Хагас жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө бараа материалын тооллого хийгээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; гэж заасантай нийцэхгүй байна.

**3.3 Төлбөрийн акт**

Төрийн албаны цалингийн нэгдсэн системд цалин бодохдоо цаг бүртгэлийг буруу оруулснаас үүдэн цалинтай чөлөө авсан албан хаагчдын цалинг бүтэн бодож, 1.6 сая төгрөгийн цалин илүү тооцоолж олгосон. Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн цаг бүртгэлд цалинтай чөлөөг тусад нь салгаж оруулдаг бөгөөд ингэснээр цалинтай чөлөөтэй өдрийн үндсэн цалинг олговор байдлаар олгодог. Иймээс илүү олгосон 1.6 сая төгрөгийн цалинг төсөвт буцаан төвлөрүүлэх.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төлөвлөгөөг дутуу тайлагнасан | 1 | 93,336.00 | 1 | 93,336.00 | | | 1 | 93,336.00 | | | | |
| | 1 | 93,336.00 | 1 | 93,336.00 | | | 1 | 93,336.00 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төрийн захиргааны албан тушаалд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа албан хаагчид 5 жил тутамд 1 удаа олгох мөнгөн урамшууллыг олгохдоо сүүлийн 5 жилийн нийгмийн даатгалын лавлагаа хавсаргаагүй, өмнөх онуудын (2018-2022) лавлагаа хавсаргасан | 1 | 16,029.0 | | | | | 1 | 16,029.0 | | | | |
| Оффисын барилгын ашиглалтын гэрээний төлбөрийг орлого, зардалд бүртгэсэн | 1 | 19,262.9 | | | | | 1 | 19,262.9 | | | | |
| Хагас жилийн бараа материалын тооллого хийгээгүй | 1 | 2,328,167.2 | | | 1 | 2,328,167.2 | | | | | | |
| Цалин илүү олгосон | 1 | 1,636.1 | 1 | 1,636.1 | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **2,365,095.2** | **1** | **1,636.1** | **1** | **2,328,167.2** | **2** | **35,291.9** | **-** | **-** | **-** | **-** |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлб | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | |